



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2025 оны 1781 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт, шинэчлэлт (Улаанбаатар хот, Багахангай дүүрэг) ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны

дарга:	О.Содовжамц	Худалдан авах ажиллагааны албаны дарга
Гишүүд:	Л.Бадрах	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ын инженер
	Ө.Амарзаяа	Нийгмийн хөгжлийн хэлтсийн боловсрол, соёл, урлаг хариуцсан ахлах мэргэжилтэн
Нарийн бичиг:	С.Өлзийсайхан	1 дүгээр хорооны иргэн
	Д.Амгалан	Худалдан авах ажиллагааны албаны ахлах мэргэжилтэн

2.Хууль, тогтоомжийн дагуу ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Үнэлгээний хороо (О.Содовжамц)-нд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД